

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.040.30

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисыг индикаторын гуурсаар тодорхойлоход тавих ерөнхий шаардлага. Occupational safety and health. General requirements for the determination of toxic substances by the detector tube in the air of work place.	MNS 5028 : 2001
--	------------------------

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2001 оны 04-р сарын 26-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2001 оны 06 -р сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын бүх шаардлагыг заавал мөрдөнө.

1 ХАМРАХ ХҮРЭЭ

Энэ стандарт өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны агаарт байгаа хорт бодисыг индикаторын гуурсаар тодорхойлох үйл ажиллагаанд мөрдлөг болгоно.

2 АРГЫН МӨН ЧАНАР

Энэхүү шинжилгээний арга нь индикаторын гуурсад байгаа хатуу бодисын гадаргууд шинжилж буй бодис шингээхэд, тэдгээрийн хооронд явагдах урвалын үр дүнд хатуу бодисын өнгө хувирах процессд үндэслэнэ.

2. ХЭРЭГЛЭХ БАГАЖ ХЭРЭГСЭЛ

3.1 Модел 8014КА маркийн сорох насос (Модел AP-1, 400А, 400 маркийн сорох насоснуудаар дээж авах зарчим нь Модел 8014КА маркийн сорох насостай ажиллах ерөнхий зарчим, хүчин чадлын хувьд ижил учир дээрх төрлийн насосуудыг хэмжилтэд ашиглаж болно)

3.2 Хорт хий илрүүлэгч индикаторын гуурсууд

4 СОРЬЦ АВАХ

4.1 Индикаторын гуурсны хэмжих хязгаарыг агаар дахь хорт бодисын агууламжид тохируулан сонгож авна.

4.2 Индикаторын гуурсны хоёр үзүүрийг багажны зориулалтын нүхэнд хийж хагалан сорох насосд зай гаргалгүй хийж бэхэлнэ. Хэрэв цэвэрлэгч хоолойг хэрэглэх бол түүнийг индикаторын гуурсад зай гаргалгүй холбоно.

4.3 Сорьц авахдаа дээж авагч насосыг ажилтны амьсгалын түвшинд байрлуулж, насосны бариулаас татан, хорт бодис илрүүлэгч индикаторын гуурсад явагдах химийн урвалын шинж чанараас хамааран өгөгдсөн хоолой тус бүрийн дээж авах агаарын эзлэхүүний дагуу агаараас сорьц авах ба сорьц авч эхэлмэгц бариулыг 90⁰-аар эргүүлэн түгжинэ.

4.4 Насосны индикатор сорьц авч дууссаныг заасны дараа насосны бариулыг анхны байрлалд буцаана. Сорьц авах эзлэхүүн гүйцээгүй бол дээрх үйлдлийг дахин давтана.

5 ХЭМЖИЛТИЙГ УНШИХ, АЛДААГ ТООЦОХ

5.1 Дээж авч дууссаны дараа индикаторын гуурсны өнгөний хувирлын хуваарь дээрх хэмжээг уншина. Хэрэв өнгөний хувирлын хуваарь дээрх хэмжээ нь бохирдолттой байвал энэ бохирдолтын дээд, доод хэмжээний төвөөр нь тооцож хэмжээг авна.

5.2 Хэмжилтийн дүнг 20⁰C (68⁰F)-ийн температур, 1013hPa-ийн даралтад унших ба бусад тохиолдолд алдаа тооцно.

5.3 Хорт бодис илрүүлэгч индикаторын гуурсад явагдах химийн урвалын шинж чанараас хамааран хэмжилт хийх үеийн температур, индикаторын гуурсны бохирдлын хэмжээ хоёроос хамаарсан алдааны хүснэгтийн дагуу алдааг тооцно. Ингэж уншсан хэмжээ нь хэмжилтийн жинхэнэ утга болно.

6. АРГАД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

6.1 Хорт бодисын агуулгыг тогтоохдоо тусгай маягт протокол хөтөлж хэмжилтийн дүнг бичнэ

6.2 Дээж авагч багаж хэрэгслийн баталгаажилт, тохируулга хийсэн эсэх, индикаторын гуурсны ашиглалтын хугацаа дуусаагүй, бүрэн бүтэн байдлыг шалгасны дараа хэмжилт хийхэд бэлтгэнэ.

6.3 Хэмжилт хийх объектынхоо талбай, хэмжээ, хорт бодисын шинж байдлаас хамаарч сорох насосыг байрлуулах цэг, индикаторын гуурсны тухайн бодисыг хэмжих хязгаар, соруулах агаарын эзлэхүүнийг судалж, тогтооно.

6.4 Хэмжилтийн ажлыг нэг цэгт 2-оос доошгүй удаа хийж, дундач утгыг авна.

6.5 Тоног төхөөрөмж, машин механизмаас үүсэлтэй хорт бодисын ууршилтыг хэмжих үед түүний ажлын горим нь ашиглалтын нөхцөл дэх горимтой тохирч байх ёстой. Ашиглалтын нөхцөл гэж тодорхой үйлдэл, үйл ажиллагааны хамгийн түгээмэл нөхцөлийг (цаг хугацаагаар, тохиолдлын тоогоор) хэлнэ.

6.6 Ажлын байранд байгаа цэвэр агаар оруулах, бохир агаар сорох төхөөрөмжүүдийг ажиллаж байх үед сорьцоо авна.

6.7 Хяналтын шинжилгээг байгаа нөхцөлөөр нь (агаар соруулах систем нь шатсан бол тэр үеийн байдлаар) авна.

ТӨГСӨВ.